

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/34/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: З.Мөнгөнцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН УУЛ АЙМГИЙН ХОНГОР
СУМЫН ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ
САНГИЙН ДАРГА Т.АТАРХИШИГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын иргэдийн төлөөлөгчдийн 02 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Хоршоог хөгжүүлэх сангаас олгогдох хөнгөлөлттэй зээлийн дээд хэмжээ иргэн аж ахуй нэгжид 30,000.0 мянган төгрөг, Зээлийн хүүг жилийн 3 хувь, зээлийн хугацааг 36 сараар тус тус баталсан.

Аудитын гол асуудал

Сумын иргэдийн төлөөлөгчдийн 2023.04.17-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Хоршоог хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн товыг тогтоосон бөгөөд төсөл сонгон шалгаруулах 2 удаагийн хурлын шийдвэрийг үндэслэн Сумын Засаг Даргын 80, 183 дугаар захирамжаар нийт 13 иргэнд 242,300.0 мянган төгрөгийг олгохоор шийдвэрлэн 1 иргэн өөрийн хүсэлтээр төслийн зээлд хамрагдахаас татгалзаж нийт 12 иргэнд 238,600.0 төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.

0090701305

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 12 зээлийн арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн сумын ИТХ-д ажлын тайланг хүргүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн адийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	340,246,555.76	345,842,819.76
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	226,625,977.70	108,582,716.70
312	Банкинд байгаа	226,625,977.70	108,582,716.70
31211	Төрийн сангийн харилцах	226,625,977.70	108,582,716.70
33	АВЛАГА	113,552,078.06	237,260,103.06
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
335	Бусад авлага	113,552,078.06	237,260,103.06
331	Ажиллагчидтай холбоотой авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага	113,552,078.06	237,260,103.06
	Найдваргүй авлагын хасагдуулга		
35	БАРАА МАТЕРИАЛ	68,500.00	-
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	68,500.00	-
35410	Бичиг хэргийн материал	68,500.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
392	Биет хөрөнгийн дүн	-	-
39201	Барилга байгууламж		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	340,246,555.76	345,842,819.76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	340,246,555.76	345,842,819.76
51	Засгийн газрын хувь оролцоо	340,246,555.76	345,842,819.76
511	Засгийн газрын оруулсан капитал		
51101	Орон нутгийн төсвийн оруулсан		
512	Хуримтлагдсан үр дүн	340,246,555.76	345,842,819.76
51210	Өмнөх үеийн үр дүн	340,246,555.76	340,246,555.76
51220	Тайлант үеийн үр дүн		5,596,264.00
51300	Дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	340,246,555.76	345,842,819.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,227,363.00	7,292,350.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,227,363.00	7,292,350.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,227,363.00	7,292,350.00
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,227,363.00	7,292,350.00
2	Үйл ажиллагааны зардал	1,726,450.10	1,696,086.00
21	Урсгал зардал	1,726,450.10	1,696,086.00
210	Бараа, үйлчилгээний зардал	1,726,450.10	1,696,086.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	1,726,450.10	1,696,086.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,726,450.10	1,696,086.00
3	Үйл ажиллагааны үр дүн	3,500,912.90	5,596,264.00
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
2250011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал		
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	3,500,912.90	5,596,264.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	100,355,287.58	122,184,325.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,355,287.58	122,184,325.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,355,287.58	122,184,325.00
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	100,355,287.58	122,184,325.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,355,287.58	122,184,325.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,701,750.10	1,627,586.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,701,750.10	1,627,586.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,701,750.10	1,627,586.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	1,701,750.10	1,627,586.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,701,750.10	1,627,586.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	98,653,537.48	120,556,739.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	30,000,000.00	238,600,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	30,000,000.00	238,600,000.00
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(30,000,000.00)	(238,600,000.00)
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	68,653,537.48	(118,043,261.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		226,625,977.70
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	226,625,977.70	108,582,716.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	336,745,642.86	336,745,642.86
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			3,500,912.90	3,500,912.90
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	340,246,555.76	340,246,555.76
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			5,596,264.00	5,596,264.00
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	345,842,819.76	345,842,819.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	5,000,000.00	1,627,586.00	(3,372,414.00)	32.6
21	Урсгал зардлын дүн	5,000,000.00	1,627,586.00	(3,372,414.00)	32.6
210	Бараа үйлчилгээний зардал	5,000,000.00	1,627,586.00	(3,372,414.00)	32.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	5,000,000.00	1,627,586.00	(3,372,414.00)	32.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	5,000,000.00	1,627,586.00	(3,372,414.00)	32.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	308,087,600.00	238,600,000.00	(69,487,600.00)	77.4
230001	Эргэж төлөгдөх зээл	308,087,600.00	238,600,000.00	(69,487,600.00)	77.4
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	313,087,600.00	122,184,325.00	(190,903,275.00)	39.0
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого	313,087,600.00	122,184,325.00	(190,903,275.00)	39.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,400,000.00	122,184,325.00	31,784,325.00	135.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	222,687,600.00	-	(222,687,600.00)	0.0
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		226,625,977.70	226,625,977.70	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		108,582,716.70	108,582,716.70	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 7,354.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

5.3.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

5.3.2.1 Илрүүлэлт: Тайлант онд 7,292.4 мянган төгрөгийн хүүгийн орлогыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

5.3.2.2 Өгсөн зөвлөмж: Хүүгийн орлогыг ибаримтаар баталгаажуулж байх

5.3.2 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

5.3.2.1 Илрүүлэлт: Тус сангаас иргэн С.Цэнд-Аюуш 2023/09 тоот гэрээ, Х.Чаминчимэг 2023/05 тоот 2023.06.12-ны өдрийн зээлийн гэрээний зээл эргэн төлөгдөх хувиарийг буруу тооцсоноос 62.0 мянган төгрөжилүү суутгаж хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрсөн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.3.2.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжыг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 7,292.4 мянган төгрөгийн хүүгийн орлогыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.	1	7,292.4	-	-	-	-	1	7,292.4	-	-	-	-
Тус сангаас иргэн С.Цэнд-Аюуш 2023/09 тоот гэрээ, Х.Чаминчимэг 2023/05 тоот 2023.06.12-ны өдрийн зээлийн гэрээний зээл эргэн төлөгдөх хувиарийг буруу тооцсоноос 62.0 мянган төгрөгийг суутгаж хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.	1	62.0	-	-	-	-	1	62.0	-	-	-	-
Дүн	2	7,354.4	-	-	-	-	2	7,354.4	-	-	-	-

